



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2021.4.29 № 6-1/2226

танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ГЗБГЗЗГ/202101007 дугаартай “Өндөрийн 1 дүгээр ангийн сүлжээ байгуулах /55 цэг/” ажлын гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Тэгш хэм групп” ХХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.


“Тэгш хэм групп” ХХК-ийн ирүүлсэн гомдолд захиалагч тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 5.2(к)-д заасан нөхцөл болох туслан гүйцэтгүүлэх ажлын гэрээний үнийн дүнгийн 30 хүртэлх хувиас хэтэрч 78 хувь хүрсэн гэж татгалзсан шийдвэр үндэслэлгүй, өндрийн сүлжээ шууд урвуу хэмжилтийн ажил нийт ажлын 80 хувь бөгөөд тус ажлыг гүйцэтгэх ажлын туршлага болон багаж тоног төхөөрөмжийн чадамжтайг баталсан талаар дурдаж, тендер шалгаруулалтын үнэлгээг шалгахыг хүссэн байна.

“Тэгш хэм групп” ХХК-ийн ирүүлсэн тендерээс үзэхэд “Геосет” ХХК-тай байгуулсан туслан гүйцэтгэгчийн гэрээнд хоёр талын гэрээгээр хүлээх үүрэг, гүйцэтгэх ажлын тоо хэмжээ, гэрээний үнэ төлбөрийн дүн заагаагүй байх тул тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТООЗ 5.2(к)-д “Тендерт оролцогч туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн 30 хувь хүртэл байна...” гэж заасан шаардлагыг хангахгүй гэж үнэлсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Тэгш хэм групп” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.НАРАНЦОГТ

9761004111